# МОНГОЛЧУУДЫН НОМЫН ӨВ СОЁЛЫГ МЭДЭХ

ХИЧЭЭЛ

# ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- Номтой хүн-Журамтай хүн
- Номын хүн-Ёс жаягаасаа хазайдаггүй хүн
- Номын өв-Өвөг дээдсээсээ өвлөж ирсэн сургаал айлдваруудыг аман болон бичгийн хэлбэрээр хадгалах

# “НОМ” ХЭМЭЭХ ОЙЛГОЛТЫН ТОДОРХОЙЛОЛТ

01 Туурвин бүтээсэн бичиг зохиол

02 Буддын гүн ухааны ном

03 Эрдэм мэдлэг

04 Ёс дүрэм, журам

# НОМ-АРИУН ЭРДЭНЭ

Т.**Галсан**

Номон дээр гишгэдэггүй
Номоо дээш нь залдаг
Ном бүтээлгэх нь дээдийн буян

**Өөрсдөө даалимба хөдөс өмсдөг**
**Үр ачаа нэхийд өлгийддөг**
**Номоо торгонд баринтагладаг**



# Монголын бичиг үсгийн баяр тэмдэглэн өнгөрүүлэх тухай

- **Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийн дагуу жил бүрийн тавдугаар сарын эхний ням гаригийг “Үндэсний бичиг соёлын өдөр” хэмээн тунхагласан юм.**
- Энэ жил уг өдрийг “Үндэсний бичиг үсэг-Тусгаар тогтнол” уриан дор явагддаг.
- Хичээлийн шинэ жилийн эхний хичээлийг Монгол бичиг түүх, соёлоо мэдэх хичээлээр эхлүүлдэг болсон
- Булган аймагт 2021 оныг “Үндэсний өв-бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх жил” болгон зарлаад байна
- 2025 оноос төрийн албан хэргийг Кирилл болон Монгол бичгээр хөтлөн явуулах
- Төрийн албаны шалгалтын 30 % нь Монгол бичгийн мэдлэгээр шалгаж байна
- Элсэлтийн ерөнхий шалгалт өгөх бүх сурагчдаас монгол хэл бичгийн

# МОНГОЛ БИЧГИЙН ҮҮСЭЛ

- Хэмүү- Шүдээр юм хэмлэн зураас үлдээх
- Зангилаа-
- Зурлага
- Татлага
- Гогцоо
- Тамга
- Угалзан
- Сийлбэр

Монгол бичгийн ацаг шүд нь Эртний Шумерын гурвалжин дүрснээс бүтсэн Шаантаг бичгээс үүсэлтэй.Монгол бичиг нь ачаа татлагын дээс гогцооноос үүдэгдэн гэдэс титэм бүхий зурлагатай болсон

# ДАСГАЛ АЖИЛЛАХ



## Дасгал 4

*Доор бичсэн номтой холбоотой цээр ёсыг мэдэж, өөрсдийнхөө мэдэхийг нэмж бичнэ үү.*

- Ном бичгийг хүндлэхийн учир дээд талыг нь буруу харуулах, доош унагахыг цээрлэнэ. Зөрчвөөс алдас болно.
- Ном судрыг сэвтээх, урахыг цээрлэнэ. Үл хэрэгсвээс эрдэм ном сурах заяа буян зайлна гэнэ.
- Ном бичиг хүнд өгөх, урилга заллагын бичиг гардуулахдаа толгой талыг нь авч буй хүний өөдөөс хандуулахыг цээрлэнэ. Заавал өөрийн бие өөд харуулж өгдөг нь цаад хүнээ хүндэлж буйн тэмдэг бөлгөө.
- Ном бичиг үзэж байгаад дэлгээтэй нь орхихыг цээрлэнэ. Зөрчвөөс мартамхай болно гэх буюу ном муу сурна гэнэ.

## Дасгал 5

Ном эрдэм сурсны болон эс сурсны ач тус хийгээд хор уршгийн талаар дараах зүйр үгээс үүдэн ярилцаарай.

Эрдэмтэй хүн далай
Эрдэмгүй хүн балай
        Эдээр биеэ чимэхээр
        Эрдмээр биеэ чим
Эрдэмт хүн даруу
Их мөрөн дөлгөөн

105. Түдэв.Л., МУЗ дээж. 108 ботийн нэгдүгээр ботийн удиртгал. 1994

# МОНГОЛ БИЧГИЙН БЭЛГЭДЭЛ, ХҮНДЭТГЭЛИЙГ МЭДЭХ



Монгол хүн бэлгээрээ
Хятад хүн мэхээрээ
Тангад хүн шидээрээ



# МОНГОЛ БИЧГИЙН БЭЛГЭДЭЛ, ХҮНДЭТГЭЛИЙГ МЭДЭХ

Хэрэв монгол бичигт эвэр хэмээх зурлага үгүй, ганц уруугаа унжсан гэзэг хэмээх зурлага байсан бол их л бэлгэдэлгүй бичиг болох сон. Үгийн төгсгөлийг сүүл “н” гарган бичиж, хүндэтгэл утгыг илэрхийлэх ёс буй. Жишээлбэл, монгол хүн төрөө дээдлэх тул “яаму” бус “яамун” ( ᠶᠠᠮᠤᠨ ), орчлонд ганц байх нар, сарыг эрхэмлэн “нара”, “сара” бус “наран” ( ᠨᠠᠷᠠᠨ ), “саран” ( ᠰᠠᠷᠠᠨ ), малчин ард буянт малынхаа сүүг ихэд дээдлэн бэлгэшээхийн учир сүүг “сү” бус “сүн” ( ᠰᠦᠨ ) гэж бичдэг.

Монгол бичгийн бүх зурлага нар зөв эргэлттэй байдаг нь мөнөөх монгол ёс заншил, бэлгэдэлтэй холбоотой ажээ. Монгол хүн нарны эргэлтийг зөв, сайн зүг хэмээн бэлгэдэх тул монгол үсгийг холбон бичихдээ гарын хөдөлгөөн ямагт нэг чигт буюу нарны эргэлттэй тохирч байхаар үсгийн зурлага, бичлэгийг бодож боловсруулжээ.

“Заргын сүүл” хэмээх нэр нь угтаа монгол бэлгэдэл (ёр зүй) ёсны уламжлалтай агаад зарга заалдсан бичигт энэхүү сүүлийг бичдэг. Заргын сүүлийг бичихдээ монгол бичгийн нар зөв эргэлттэй зурлагын бэлгэдлийг зориуд зөрчин, өөрөөр хэлбэл, бэлгэдлийг ёрлон нар буруу эргүүлэн бичдэг

**Үндэсний монгол бичиг мэдсэний ач тус**

- Түүх шастираа өөрөө уншиж ухаарна.
- Зан заншлаа гүнзгий мэднэ.
- Гадаад ертөнцөд уламжлалт бичиг үсгээ сурталчилж чадна.
- Үр хүүхдэдээ заан сургаж чадна.

**Үндэсний монгол бичгээ мэдэхгүйн хор уршиг**

- Судар номоо уншиж чадахгүй.
- Уламжлалт өв соёл, шашны талаар гүн гүнзгий мэдэж чадахгүй.
- Уламжлалт бичиг үсгээрээ бахархаж чадахгүй.

# Төр оршихуй дор бичиг үсэг оршино
# Бичиггүй төр байж үл болно

МОНГОЛ БИЧИГ

- Тод бичиг

  Ойрадын лам Зая Бандид Намхайжамц 1648 онд зохиосон

- Вагиндрагийн үсэг

  Буриадын лам Агваанд орж 1205 онд зохиосон

- Манж үсэг

# ГЭРИЙН ДААЛГАВАР

- Сурах бичиг 106 хуудас Дасгал-1 ажиллах